



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/98

Булган сум

“Смарт электрик инженеринг” ХХК-тай гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, Засгийн газрын 2024 оны 01 дугаар сарын 03-ны өдрийн “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 108-р тушаалаар батлагдсан “Зураг төслийн жишиг үнийн дүрэм” БД81-16-20, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 сарын 05-ний өдрийн XIX/08 дугаар хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” тогтоолын 4 дүгээр хавсралтын 2.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/58 дугаар захирамжийн хавсралтын 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн Бүрэгхангай сумын Бүрэгхангай сумын “Цахт” 2 дугаар багт байрлах үтрэмийн гадна цахилгаан хангамжийн 35/10 кв-ын Бүрэгхангай дэд станцын 10 кв-ын №5-ын өргөтгөл, 10 кв-ын цахилгаанд дамжуулах агаарын шугам, 10/04 кв-ын 160 ква дэд станцын ажлыг 16,000,000 (арван зургаан сая) төгрөгөөр “Смарт электрик инженеринг” ХХК-тай гэрээ байгуулах эрхийг аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Давааням)-д олгосугай.

2. Гэрээнд заагдсан ажлыг тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэн хүлээлгэн өгөхийг “Смарт электрик инженеринг” ХХК-ийн захирал (Л.Эрдэнэбаатар)-д үүрэг болгосугай.

3. Булган аймгийн Бүрэгхангай сумын Бүрэгхангай сумын Цахт 2 дугаар багт байрлах үтрэмийн гадна цахилгаан хангамжийн 35/10 кв-ын Бүрэгхангай дэд станцын 10 кв-ын №5-ын өргөтгөл, 10 кв-ын цахилгаанд дамжуулах агаарын шугам, 10/04 кв-ын 160 ква дэд станцын ажилд чанарын болон хугацааны хяналт тавьж хүлээн авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн бөгөөд аймгийн Ерөнхий архитектор (М.Цэрэнчимэд)-т даалгасугай.

4.Дээрх ажлуудын санхүүжилтийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн батлагдсан төсвөөс гэрээнд заагдсан үнийн дүнгээр санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ